



БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2021 оны 08 сарын 08, өдөр

Дугаар 1/61

Өлгий

Г

Ажлын хэсэг байгуулах тухай

Г

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь заалт, Барилгын тухай хуулийн 37 дугаар зүйлийн холбогдох заалтууд, Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолын Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрмийн 1 дүгээр хавсралтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Гадаадын хөрөнгөөр санхүүжигдэж "Нурбах" ХХК-ийн хийж гүйцэтгэсэн Сагсай сумын 6-р баг Даян бага эмчийн салбарын барилгын засварын ажлыг хүлээж авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга:

С.Бекет- ЭМГ-ын Барилгын чанар, аюулгүй байдал, эмнэлгийн тоног төхөөрөмж, засвар үйлчилгээ хариуцсан ажилтан

Гишүүд:

Т.Нурлан- Сагсай сумын ЭМТ-ийн дарга эмч

Х.Жахсыгүл- Мэргэшсэн төсөвчин

Н.Нарима - "Нурбах" ХХК-ийн захирал

Нарийн бичгийн дарга:

Д.Тилеуберди- Хот байгуулалт, Барилга захиалагчийн албаны хяналтын инженер

2. Тус засварын ажлыг зураг төсөв, норм, нормативын баримт бичигт заасан техникийн үзүүлэлт, стандарт шаардлагын дагуу гүйцэтгэсэн эсэхийг хянан дүгнэж, зохих хууль тогтоомжийг баримтлан ашиглалтад оруулах үйл ажиллагааг зохион байгуулахыг ажлын хэсэг (С.Бекет)-т үүрэг болгосугай.

3. Уг ажлыг хөрөнгөд бүртгэх ажлыг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулж ажиллахыг Сагсай сумын ЭМТ-ийн дарга (Т.Нурлан)-д үүрэг болгосугай.

4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ЭМГ-ын ахлах мэргэжилтэн (А.Ерганат)-д даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ  Х.ДАУЫРЖАН



